




Эсгий урлал

ЭНЭ ЯМАР АМЬТАН БЭ?



Сэдэв: Эсгий урлал

Зорилго:

Эсгий урлалын түүх


Эсгий хийх арга танилцах

Эсгий хийх бүтээл судлах

Ширхэглэгийн ангилал



Ширхэглэгийн ангилал



Ноосон ширхэглэг:

- * Ноос гэдэг нь амьтны үсэн бүрхүүл бөгөөд ийм ширхэглэгийн урт нь 20-450 мм байдаг. Ноосон ширхэглэгийн шинж чанар нь ноосны бат бөх, зузаан, уян хатан, уртаар тодорхойлогдоно. Ноос нь цагаан, шаргал, саарал, хар, гэх мэт янз бүрийн өнгөтэй байдаг. Ноосон ширхэглэг нь шатахдаа удаан мушгирч шаргал дөл, хярвас, ясны үнэр гаргадаг. Хар өнгөтэй бөөрөнхий үнс үлддэг.

Эсгий бол нүүдэлчин монголчуудын ахуй амьдралын салшгүй нэг хэсэг. Монголчуудын соёл, ахуй, зан заншил, байгаль орчинтойгоо шүтэлцэн амьдрах ухаан, ертөнцийг үзэх үзэл гээд бүхий л зүйл эсгийнд шингэжээ.

- * Эсгий урлал нь өөрийн гэсэн ёс горим, цээртэй. Эртнээс нааш монголчууд эсгийг ариун зүйл гэж үзсээр ирсэн. Шинэ эсгийн дээр шинэ бэр буулгаж авна. Хүүгийнхээ зүүдийг аргадах үнэг, овгийн шүтээн онгодоо хүртэл эсгийгээр урладаг.

* Эсгий хийж байгаа газар согтуу хөлчүү хүн, хэрүүл тэмцэл гаргахыг цээрлэдэг. Холоос ирсэн хүн эсгий хийж буй газар шууд очдоггүй ёстой. Замын цээрээ арилгаж айлд орж, цай идээ амссаны дараа эсгий хийх газар очдог. Эсгий хийх газар нохой хэрэггүй гэдэг. Энэ нь нохой эсгий рүү сарьж бузартуулахаас сэргийлсэнийх юм. Нөгөө талаас нохойн үс ширэлдэх, эсгийрэх чанараар сул болохыг анзаарчээ. Энэ бүхэн нь ноосны амин чанарыг таньсан ардын билиг ухаан юм.

Эсгий урлалын бүтээгдэхүүний онцлог давуу тал нь юунд оршдог вэ ?

- * Эсгий бүтээгдэхүүн нь хүйтэнд дулаан, дулаанд сэрүүн байдаг. Энэ нь ноос гэх түүхий эд нь амьсгалдаг материал бөгөөд чийгшил их үед чийгийг шингээгээд дулаан болгон гаргадаг зэргээс түүний ил үзэгдэх онцгой шинжийг харж болно. Мөн ноос нь галд тэсвэртэй. Монгол хонины ноосны шаталтын температур нь 560 цельсийн градус байдаг учраас шаталт бага явагддаг юм. Мөн шаталтаас болон халалтаас үүдэлтэй дулаан нь хадгалагдаж үлддэг.

* Ноос, ноосон бүтээгдэхүүн нь дуу чимээ тусгаарлах, хорт бодис шингээх чанартай. Ноосоор хийсэн дулаалгын материал, хэрэглэл нь шилэн хөвөнтэй харьцуулахад дуу чимээг 20 хувиар бууруулдаг бөгөөд хорт хийг шингээн түүнийг сарниулах шинж чанартай.

* -арьсанд тэжээл өгч чийгшүүлэх
- хуурай арьсны тослогийг тэнцвэржүүлэх
- үрэвсэл намдаах, бактери устгах гэх мэт үнэт чанаруудтай.

Эсгий төрөл, найрлага

- * **Эсгий найрлага нь:**
- * **Цэвэр ноос** - хамгийн үнэтэй нэг; ихэвчлэн хязгаарлагдмал сүүдэрт будсан байдаг. Бактерийн эсрэг сайн шинж чанартай байгаль орчинд ээлтэй материалыг хүрэхэд маш тааламжтай; энэ нь ихэвчлэн хүүхдийн хувцас, тоглоом оёход ашиглагддаг. Ноосон эсгий нь сул талтай бөгөөд угаах, индүүдэх үед амархан хэв гажилт үүсгэдэг тул нямбай арчилгаа шаарддаг.
- * **Ноосны холимог** - нийлэг утас (нийлэг эсвэл наалдамхай) нэмсэн. Энэ нь тод өнгөөр будсан, өөр өөр зузаантай байж болно. Хувцас оёх, тоглоом, гоёл чимэглэл, аппликейшн хийхэд тохиромжтой.
- * **Синтетик** - хамгийн хямд үнэтэй эсгий. Энэ нь 100% нийлэг, вискоз эсвэл полиэстр агуулдаг. Ийм эсгийг хувцас хийхэд ашигладаггүй боловч хүүхдийн төрөл бүрийн гар урлал, аппликейшн болон бусад зүйлд нэлээд тохиромжтой байдаг. Синтетик эсгийний давуу талууд нь баян, тод өнгө, бат бөх, удаан эдэлгээтэй байдаг. Сул талууд нь зарим тааламжгүй "чимээ шуугиан", харьцангуй ил тод байдал юм.
- * Үүнээс гадна эсгий нь зузаан (зузаан, хагас нимгэн, нимгэн) ба [гадаад төрх](#) (гөлгөр эсвэл ширүүн)

Эсгий урлалын түүхий эд



ЭСГИЙ ХИЙСЭН БҮТЭЭЛҮҮД



Эсгий урлалын бүтээлүүдээс
санаа авч бүтээл эсгий таавчиг
хийсэн байдал

Эсгэх ажиллагаа



- * Хайчаар ажиллах аюулгүй ажиллагаа
- * Эсгүүрийн зургийн дотор хүрээгээр хайчлах
- * Хайчийг тэгш барих
- * Хайч нь зориулалтын хурц байх
- * Дараах бүрдэл хэсгүүдийг хайчилж сурна




Эсгүүрээ шахаж байрлуулан зурж хайчилна

РАЗ 36

* 50см x 50см 1ш шаахай 5000 төг



Оёх технологи



- * Толгой оёх
- * Чимэглэл оёх
- * Ул ширэх
- * Ул толгой холбох
- * Улны савхи оёх

ЭЦСИЙН БҮТЭЭГДЭХҮҮН



ЧИМЭГЛЭЛ

- * Хагас ноосон материал буюу синтетик материал ихэвчлэн гоёл чимэглэл ашигладаг бөгөөд янз бүрийн өнгө хэмжээ бүтэц нь өөр өөр байдаг. Орчин үед түгээмэл хэрэглэж байна.





Сонирхолтой мэдээлэл

Гэрийн эзэн уг ажилд дадлага туршлага муу бол эсгий сайн хийдэг гэж алдаршсан хүндтэй хүнийг зориуд урьж авчран эсгий хийх ажлыг удирдуулдаг байна. Ингээд нэг үе ноос зулаад усаар жигд сайн шүршинэ. Усаар жигд нарийн сайн шүршиж норгосны дараа ахин нэг үе ноос зулж мөн усаар нэвт шүршиж норгоно. Ингээд сүүлийн үе "зулхай" гэж ахарын ноос, хурганы ноос зулах ба энэ үе нь өнгөн тал болох тул хар, бор зэрэг өөр өнгө ороогүй жигд цагаан ноос зулдаг. Зулхай зулсны дараа эрэгтэйчүүд гол мод хийж завсар нь цахилдаг зэрэг өвсөөр наалдахгүйгээр үе тавьж чанга хуйлан гадуур нь дэвтээсэн ширээр ороож ширнийхээ хоёр амыг үдээсээр чангалан үднэ. Хоёр үзүүр нь задгай үлдсэнийг үдэхдээ "умбай тумбай" гэж хэлж усаар сайн шүршиж норгоод үдээсээр сүлжин бөхөлж уяад хөвч гэж тусгай нарийн сураар хооронд нь холбож уяна. Эсгий хийж байхад ирсэн хүн бүхэн

Цагаан эсгий цавгүй

Цааш нааш гавгүй

Цаснаас цагаан

Яснаас хатуу

Мөснөөс гөлгөр

Мөнгөнөөс үнэтэй

Эвдрэхгүй мөнх

Элэгдэхгүй бат

Дун шиг өнгөтэй

Дурдан шиг артай болтугай

асуулт

1. Ноосон ширхэглэгийг хаанаас гаргаж авдаг вэ?

- A. Хүр хорхойн авгалдай В. Хонь
C. Хөвөнгийн ургамал D. Олсны
ургамал

2. Байгалийн гаралтай ширхэглэгийг хэд ангилдаг вэ?

- A. 2 В. 3 C. 4 D. 5

3. Ямар ширхэглэг хярвас ясны үнэр гарган шатах вэ?

- A. Хөвөн В. Олсон C. Ноосон D. Торгон